

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга		
Хуралдааны товч тэмдэглэл:		1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:		4-26
1.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан		4-26

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан
03 дугаар сарын 18-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 49 гишүүнээс 25 гишүүн хүрэлцэн ирж, 51.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Э.Батшугар, Ж.Баярмаа, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, Н.Номтойбаяр, Р.Сэддорж, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ө.Шижир, С.Бямбацогт, Б.Батбаатар, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Одбаяр;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, П.Сайнзориг, Д.Энхтүвшин.

Нэг.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Х.Баярмаа, А.Мөнхбадрал, М.Наранжаргал, Г.Сарангоо, Б.Сандуйжав, С.Оюун-Эрдэнэ, Н.Хандмаа, Ж.Чинбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, мөн газрын ахлах референт М.Баярмаа, Д.Отгон, Д.Цэцэгмаа, ахлах шинжээч Б.Наранцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, Гадаад харилцааны яамны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал Д.Тэгшжаргал, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, О.Батнайрамдал, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Засгийн газрын гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул өнөөдрийн Байнгын хороодын хамтарсан хуралдааныг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 14

Бүгд: 27

48.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./16:16/

Байнгын хороодын хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 22 минут үргэлжилж, ирвэл зохих 49 гишүүнээс 27 гишүүн хүрэлцэн ирж, 55.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 55 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Гишүүд суудлаа эзэлье. Хуралдаанаа эхэлье. Эрхэм гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Мөн эрчүүддээ Орчин цагийн зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 104 жилийн ойн мэндийг хүргэе. Эмэгтэйчүүддээ өнгөрсөн ч гэсэн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд хамтарсан хуралдаан явагдаж байна. Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан. 2 Байнгын хорооны дарга Улсын Их Хурлын даргын гадаадад томилолттой яваа учраас миний бие Төрийн байгуулалтын байнгын хороог томилолтын хугацаанд үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байгаа учраас өнөөдрийн хуралдааныг даргалан явуулж байна.

Өнөөдрийн чуулганы Байнгын хорооны хуралдаанд Цэндийн Сандаг-Очир, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Шинэбаярын Бямбасүрэн, Хассуурийн Ганхуяг, Тогмидын Доржханд, Батбаярын Жаргалан, Сархадын Зулпхар, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Баатаржавын Мөнхсоёл, Бадрахын Найдалаа, Одсүрэнгийн Номинчимэг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Цэвэгдоржийн Туваан, Агваанлуvsангийн Ундраа, Ням-Осорын Учрал, Гончигдоржийн Уянгахишиг, Одонгийн Цогтгэрэл, Саруулсайханы Цэнгүүн, Мөнхчулууны Энхцэцэг гэсэн гишүүд одоогийн байдлаар хүрэлцэн ирээд байна. Хуралдааны ирц хүрсэн учраас хуралдааныг эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.3-д Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тухай жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ гэж заасан. Өнөөдрийн чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 1.Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газар 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг тус тус хэлэлцэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэж байгаа асуудал батлагдлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 24 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 24 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг хэлэлцье. Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Юугаа аваад ир дээ албан тушаалтнуудын нэрсийг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.8-д Тамгын газар энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланд шинжилгээ хийж, 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд тараана гэж заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас тус бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, та бүхэнд хүргүүлсэн болно.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.1-д Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ. 117.3-д Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд, хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно гэж заасан байна.

Өнөөдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, албан тушаалтнуудаас Ү.Амарбат Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Б.Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн шинжилгээний хэлтсийн дарга, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Н.Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Х.Батжаргал Боловсролын яамны ТНБД, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Н.Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Ш.Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Д.Үүрийнтуяа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын дарга, Д.Отгон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт, Д.Цэцэгмаа Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт, М.Баярмаа Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт, Б.Наранцэцэг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын ахлах шинжээч, Д.Тэгшжаргал Гадаад харилцааны яамны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал.

Мөн Улсын хөгжлийн 24 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл сэдэвт аудитын тайлангийн хэлэлцүүлэгт оролцох ажилтнуудын нэрсийг танилцуулъя. Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Д.Энхболд Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Х.Баярмаа Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, М.Наранжаргал Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Г.Сарангоо Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Хандмаа Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудиторовын газрын аудитор. Мөн

чуулганы хуралдаанд Д.Эрдэнэсамбуу Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн шинжилгээний хэлтсийн дарга, Б.Отгонсүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ мониторингийн газрын зөвлөхүүд оролцож байгаа юм байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.6-д энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланг Ерөнхий сайд эсхүл Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газар гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 24 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг Монгол Улсын Шадар сайд Доржханд танилцуулна. Доржханд гишүүний микрофоныг өгье.

Т.Доржханд: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 18 дугаар зүйлийн 18.1-д тус тус заасны дагуу Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

1.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 21-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван, аюулгүй нийгэм, бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 21-ээс 24 оны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэгжилт дунджаар 67 хувьтай байна. Үүнээс нийт арга хэмжээний 10,7 хувь буюу 26 арга хэмжээ үр дүн бүрэн хэрэгжсэн. 51,9 хувь буюу 126 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн. 33,3 хувь буюу 81 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 4,1 хувь буюу 10 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Бодлогын үндсэн 9 зорилгын хүрээнд хэрэгжилтийг авч үзвэл 1.үндэсний нэгдмэл үнэт зүйл 45 хувьтай, 2 хүний хөгжил 68,4 хувьтай, 3.амьдралын чанар ба дундаж давхарга 67,8 хувь, 4.эдийн засаг 77,4 хувь, 5.засаглал 61,2 хувь, 6.ногоон хөгжил 77,2 хувь, 7.амар тайван, аюулгүй нийгэм 83,5 хувь, 8.бүс, орон нутгийн хөгжил 50,3 хувь, 9.Улаанбаатар ба дагуул хот 50,5 хувь тус тус байна.

Хяналт шинжилгээ үнэлгээний 94 шалгуур үзүүлэлтийн 26,6 хувь буюу 25 нь улсын хөгжлийг тодорхойлох ерөнхий үзүүлэлт байгаа бол 73,4 хувь буюу 69 хувь нь, 69 нь салбарын, байгууллагын, нутаг дэвсгэрийн хүрээний үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой үзүүлэлтүүд байна. Нийт 94 шалгуур үзүүлэлтээс 63 үзүүлэлтийг хүрсэн түвшнийг тодорхойлсон байх, 31 шалгуур үзүүлэлтийн тайлагнах хугацаа болоогүй тул хүрсэн түвшнийг тодорхойлох боломжгүй байна. Дээрх 63 шалгуур үзүүлэлтийн 29,8 хувь буюу 28 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн, 7,4 хувь буюу 7 үзүүлэлт 70 хувиас дээш зорилтот түвшнийг хангасан бол 29,8 хувь буюу 28

шалгуур үзүүлэлт зорилтот түвшнээ хангаагүй байна. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын 21-ээс 25 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан тус бүр нь 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй нийт 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 61,7 хувьтай байна. 2021-ээс 24 онд нийт 45 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай нийт 98 төслөөс 54 төслийг боловсруулж, 28 төслийн боловсруулах ажил нь эхэлсэн, 16 төсөл эхлээгүй байна. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 18,6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээнээс 41 төсөл, арга хэмжээний 3,4 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2021-ээс 24 онд бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн бөгөөд 24 онд 33 төсөлд 5 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

2.Монгол Улсын Засгийн газар 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд. Монгол Улсын Их Хурлын 24 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь үндсэн 4 бодлогын хүрээнд 16 чиглэлийн 620 зорилтыг хэрэгжүүлэх тусгасан. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө албажиж батлагдаагүй тул хөтөлбөрт тусгагдсан 16 чиглэлийн зуун хорин, 620 зорилтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 оны сүүлийн хагас жилийн байдлаар дунджаар 34 хувьтай байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлого тус бүрээр харуулбал 1.бүсчилсэн хөгжлийн бодлого 25,2 хувь, 2.хүний хөгжлийн бодлого 36,4 хувь, 3.эдийн засгийн бодлого 34 хувь, 4.хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого 40,6 хувийн хэрэгжилттэй байна. Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 620 дэд зорилтоос 3 буюу 0,5 хувь нь үр дүн гарсан, 73 буюу 11,8 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 241 буюу 38,9 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай байгаа бол 104 буюу 16,8 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна. Нийт 4 бодлогын хүрээнд хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй 199 зорилт байна.

3.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийн тухайд. Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөөнд 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 24 үр дүн, хөтөлбөрийн 53 үр дүн, 194 төсөл, арга хэмжээ, 250 шалгуур үзүүлэлт тусгагдсан. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд төлөвлөгөөний биелэлт дунджаар 57,2 хувь байна. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 19,1 хувь буюу 37 арга хэмжээ үр дүнтэй, 30,9 хувь буюу 60 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 35,1 хувь буюу 68 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 14,9 хувь буюу 29 арга хэмжээ үр дүнгүй хэрэгжсэн байна.

Бодлогын тэргүүлэх чиглэл тус бүрийн хэрэгжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дунджаар авч үзвэл 1.экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 36,5 хувьтай, 2.хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 50,2 хувьтай, 3.хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 71,4 хувь, 4.аялал жуулчлалыг хөгжүүлнэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга Хэмжээ 45 хувь, 5.хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 78 хувь, 6.Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг

бууруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 59,9 хувь, 7.засаглалын үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 81 хувь, 8.ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 86,3 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт дээрх тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 48,3 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн 24 зорилтот үр дүнгийн 29 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 69,4 хувь, хөтөлбөрийн 53 зорилтот үр дүнгийн 63 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 56,96 хувийн үзүүлэлттэй байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 194 төсөл, арга хэмжээг 13,9 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,1 их наяд төгрөгийг зарцуулсан нь нийт төлөвлөсөн дүнгийн 36,4 хувийг эзэлж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг харвал 10 төрлийн эх үүсвэрээс 13994,7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл дээр 7 төрлийн 96 төсөл, арга хэмжээ нь 5, 0, 99,09 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Та бүхэн дээрх 3 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж өгнө үү. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Танилцуулга хийсэн Шадар сайд Доржхандад баярлалаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д Төрийн аудитын байгууллага улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлсэн байна. 18.4-д Төрийн аудитын байгууллага Монгол Улсын хөгжлийг 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх жилийн 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасны дагуу ирүүлсэн тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.7-д Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд аудитын тайланг Монгол Улсын ерөнхий аудитор танилцуулна гэж заасан. Гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын энэ тайлангийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав хийнэ. Танай дарга яасан юм бэ? Тайланг Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч 3 номерын микрофоныг өгье. Дарга чинь ямар шалтгаантай байгаа юм бэ? Шалтгааныг нь хэл.

Я.Самбууням: Хурал давхацсан гээд Ерөнхий аудитор гарсан байгаа. Удахгүй ороод ирэх байх. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын, Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, мөн улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд гүйцэтгэл-нийцлийн аудитыг хийж хуулийн хугацаанд тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон холбогдох байгууллагад хүргүүлсэн болно.

1.Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн

хураангуйг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсыг хөгжүүлэх 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг 9 бодлого, 47 зорилтын 243 арга хэмжээг баталсан байна. 2 дугаар хавсралтаар Монгол Улсын 2021-ээс 25 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан 9 бодлого зорилгын хүрээнд нийт 150 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Мөн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээг мөн тусгасан. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл, арга хэмжээний жагсаалтыг тус тус баталсан байна. Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байхаар тусгасан боловч Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь хяналт шинжилгээ үнэлгээний 95 шалгуур үзүүлэлт суурь болон хүрэх түвшинтэй батлагдсан ч үндсэн чиглэлд тусгагдсан 243 төсөл, арга хэмжээтэй уялдаа багатай байна.

Тодруулбал 243 төсөл, арга хэмжээнээс 108 нь шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшингүй байгаа нь хуулийн шаардлагыг бүрэн хангаагүйг харуулж байна. Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн чиглэлд дараах дүгнэлтийг Төрийн аудитын байгууллагаас өгч байна.

1.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь 67,7 хувьтай хэрэгжсэн бөгөөд нийт төсөл, арга хэмжээний 14,8 хувь нь үр дүнтэй, 50,8 нь тодорхой үр дүнд хүрсэн, 32,5 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 2,5 хувь нь үр дүнгүй гэж дүгнэж байна.

2.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу иж бүрэн, судалгаа тооцоотой боловсруулаагүйгээс төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй, гүйцэтгэлийг бодитой үнэлэхэд хүндрэл учруулж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжилд үзүүлэх үр нөлөөг бууруулж байна.

3.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн Төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх үйл явц болон төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийн шийдвэрлэлт хангалтгүй байгаа нь хууль, эрх зүйн уялдаагүй байдал, зохицуулалт дутагдалтай, мөн оролцогч байгууллагуудын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

4.Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй гүйцэтгээгүйд тооцох хариуцлагын талаарх хууль, эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий, нарийвчилсан шалгуургүйгээс хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтнууд хариуцлага хүлээхгүй байх нөхцөл бүрдсэн байна.

5.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь өөрийн зорилтот түвшинд хүрч, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хэрэгжүүлэгч байгууллагууд Эдийн засгийн хөгжлийн яам, ЗГХЭГ бодит гүйцэтгэл, холбогдох нотлох баримтад үндэслэж бодитой үнэлээгүй, зөвхөн 2024 оны гүйцэтгэлээр тайлагнаж үнэлсэн, хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр

үнэлээгүй нь 5 жил тодорхойлсон бодлого, зорилго, зорилтыг хэрхэн хангаж байгаа, цаашлаад урт болон дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлоогүй буюу зөвхөн богино хугацааны төлөвлөлт нь анхаарлыг анхаардгийг харуулж байна.

6.Эдийн засгийн хөгжлийн яам, ЗГХЭГ болон хэрэгжүүлэгч байгууллагууд төлөвлөсөн зорилт, арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж нийгэм, эдийн засагт ямар нөлөө бий болж байгааг тооцоолж үнэлээгүй нь хууль, эрх зүйн зохицуулалт дутагдалтай, уг үнэлгээ хийх тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна. Энэ шаардлагатай нь нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг хязгаарлаж, үр нөлөө багатай арга хэмжээг хэрэгжүүлж, үргүй зардал гарах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна гэж дүгнэж байна.

7.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээний хүрээнд 2021-ээс 24 онд нийт 21,7 их наяд төгрөг зарцуулсан ч нийгэм, эдийн засагт ямар эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хуралд дараах асуудлуудыг толилуулж байна.

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 9.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн Төсвийн тухай хуулийг батлахдаа тэдгээрийн хоорондын уялдаа нийцэлд анхаарах. 2.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн Үндсэн чиглэлд туссан арга хэмжээг хугацаанд нь биелүүлээгүй хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагад хариуцлага тооцох хууль, эрх зүйн зохицуулалт, шалгуурыг тодорхой болгож, холбогдох албан тушаалтад хариуцлага тооцож байх. 3.Хөгжлийн бодлогын баримт бичигт төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй судалгаа тооцоололгүй арга хэмжээг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад нэмж баталдаг асуудлыг цаашид таслан зогсоох шаардлагатай байгааг толилуулж байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдад дараах зөвлөмжийг өгч байна. 1.Улсын Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо үнэлгээг иж бүрэн хийх.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарт дараах зөвлөмжийг өгч байна. 1.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр бий болох үр нөлөөг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой төлөвлөн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, тооцоо судалгаанд үндэслэн бодитой хэмжигдэхүйц хэрэгжүүлэх хугацаа, хариуцах байгууллагыг тодорхойлж төлөвлөгөөг боловсруулж байх. 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч талуудын Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Сангийн яам зэрэг байгууллагуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хангуулах. 3.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан цогц хяналт шинжилгээ, үнэлгээг хөтөлбөр хэрэгжсэн

хугацааны нэгдсэн дүнгээр хийж, урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах. 4.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлд нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө, эерэг өөрчлөлт бий болгосныг үнэлж тооцон Үндэсний статистикийн хорооноос гаргадаг статистикийн өгөгдөлд оруулж, нийтэд ил тод ойлгомжтой хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд нарт дараах зөвлөмжийг өгч байна. 1.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлж хангах хуульд заасан чиг үүргийн хүрээнд төсөл, арга хэмжээний тоо, санхүүжилтийн зохистой харьцааг бодитой тооцож төлөвлөх. Санхүүжилтийн эх үүсвэр нь бүрэн шийдэгдээгүй асуудалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээ авах. 2.Монгол Улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн Төсвийн тухай хуульд туссан арга хэмжээний нийцэлд хууль тогтоомжийн хүрээнд тусгасан ялгаатай шаардлагад дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, шийдвэр гаргах этгээдэд уламжлах шаардлагатай байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараах зөвлөмжийг өгч байна. 1.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр бий болгох үр нөлөөг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөн, хууль тогтоомжид заасан шаардлагыг тооцоо судалгаанд үндэслэн бодитой, хэмжигдэхүйц тодорхойлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон ТББ-ын санал тооцооллын нэгтгэн боловсруулж байх. 2.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд бодит гүйцэтгэлд нотлох баримтад суурилсан цогц хяналт, шинжилгээ, үнэлгээг хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр хийж, урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлж тайлагнаж байх. 3.Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо, үнэлгээг иж бүрэн хийж, орон нутгийн иргэдийн саналыг авч, олон нийтээр хэлэлцүүлэн төлөвлөгөөнд тусгаж байх шаардлагатай байна.

2.Төрийн аудитын байгууллагаас улсын хөгжлийн 2024 жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлангийн хураангуйг танилцуулъя. Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд 8 тэргүүлэх чиглэл, 24 төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, 53 хөтөлбөрийн үр дүн, 194 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 13,9 их наяд төгрөгийн хөрөнгө шаардлагатай байхаар баталж гүйцэтгэлдээ нийт 6,4 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд шалгуур үзүүлэлт бүрээр бодлогын хэрэгжилт, үр дүнг тайлагнах, үнэлж дүгнэхээр төлөвлөсөн нь өмнөх онуудын богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгээс тодорхой ахиц бий болгосон байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын дараах дүн дүгнэлтийг өгч байна. 1.Монгол Улсын 2024 оны үндэсний хэмжээний зарим статистик тоон мэдээлэл үзүүлэлт болон ОУБ-аас гаргадаг

холбогдох тайланг гаргах хугацаа болоогүйгээс шалтгаалж 3 тэргүүлэх чиглэлийн 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хүрсэн түвшин биелэлтийг дүгнэх боломжгүй байна. 2.Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 5 тэргүүлэх чиглэлийн үр дүн 74,3 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 56,9 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээ 56,6 хувь, 194 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 52,9 хувьтай үнэлэгдсэн байна. 3.Засгийн газар эрх бүхий байгууллагаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох журамд заасан 15 хоногийн хугацаанд дунд шатын болон эцсийн хяналт шинжилгээ үнэлгээг хийхэд цаг хугацааны болон боловсон хүчний чадамж, зохион байгуулалт хангалтгүйгээс хуульд заасан зарчим, шаардлага, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, цогц хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна. 4.Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зарим төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлоогүй, улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй, мөн хуульд заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлага, Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан төлөвлөлтөд суурилсан төлөвлөлтийн зарчмыг хангаагүй, зарцуулсан хөрөнгийг үнэн зөв, бодитой тайлагнаагүйгээс нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хөрөнгийн үнэ цэнийг бүрэн бий болгож байгаа болгож чадаагүй байна гэж дүгнэж байна.

5.ҮСХ-ноос улсын хэмжээний жилийн статистик тоон мэдээллийг харилцан адилгүй хугацааны давтамжтай тархааж байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан цаглаварт хугацаанд бодлогын хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг зөв тооцож үнэлэх боломжгүйд хүргэж байна. 6.Богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөж, боловсруулах үүрэгтэй төсвийн ерөнхийлөн захирагч, Эдийн засаг, хөгжлийн яам нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан бүх талын оролцоог хангах зарчмыг баримтлаагүй, зарим төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөлгүй, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг оновчтой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй зөрчлүүд давтагдан гарч байгаагаас бодлогын хэрэгжилт зорилтод үр дүнд хүрээгүй байна гэж дүгнэхээр байна. 7.Бодлогыг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах бодлогын хувилбарыг урьдчилан төлөвлөж чадаагүй, салбарын онцлогт нийцсэн үзүүлэлт, индекс гүйцэтгэлийн чанарын стандарттай нийцсэн хяналт шинжилгээ үнэлгээний аргачлалгүй нь тухайн салбарын бодлогын үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг тооцож чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Мөн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн улсын хөгжлийн, Монгол Улсын ЗГ-т 4, Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайдад 4, Сангийн сайдад 1, Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрд 3 нийтдээ 12 зөвлөмжийг өгсөн байна. Зарим зөвлөмжөөс дурдвал Монгол Улсын Засгийн газар, Засгийн газар хяналт хэрэгжүүлэх газарт дараах зөвлөмжийг өгч байна. 1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд баталсан холбогдох хууль журмын цаглаварт хугацаанд судалгаа, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах. 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолсон, үр дүнд суурилсан

төсөвлөлт төлөвлөлтийг хийхэд чиглүүлэх. 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт тайлагналын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, ОУБ-аас тооцоологддог үзүүлэлтүүдийг дотооддоо тооцох аргачлал бүхий шалгуур үзүүлэлттэй болгох. 4.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг батлуулж байх.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдад дараах зөвлөмжийг өгч байна. 1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хэрэгжилт үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолсон байх. Үр дүнд суурилсан төлөвлөлт, төлөвлөлтийн зарчмыг хангаж төлөвлөх. 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналтын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, ОУБ-аас тооцоолдог үзүүлэлтийг дотооддоо тооцох аргачлал шалгуурыг, шалгуур үзүүлэлтийг боловсруулж бий болгох. 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлэн төлөвлөж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг гаргаж, бүх талын оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх. 4.Засгийн газрын түвшинд хэрэгжүүлж буй их өгөгдлийн сан, мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлтэй уялдсан улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийг эргэлтэд оруулах эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй олон улсын үнэлгээний цогц систем бүхий жишигт нийцсэн мэдээллийн санг хөгжүүлэх шаардлагатай байна.

Сангийн сайдад дараах зөвлөмжийг өгч байна. 1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний шаардлагатай улсын төсвөөс санхүүжих хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасан улсын хөгжлийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлагад нийцүүлэн тухайн жилийн төсвийг боловсруулахад анхаарч ажиллах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараах зөвлөмжийг өгч байна. 1.Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа шаардлагатай хөрөнгийн хэмжээг урьдчилан тооцсон, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусган хүргүүлж байх. 2.Улсын хөгжлийн богино хугацааны хөтөлбөр, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсвийн төсөлд хүргүүлэх саналд тусгаж байх. 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглэсэн бүх талын оролцоог ханган боловсруулж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж дараах зөвлөмжүүдийг өглөө. Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Танилцуулгуудыг сонсож дууслаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхсоёл гишүүн, Цэнгүүн гишүүнээр тасаллаа. Батчимэг гишүүний нэр орохгүй байна гэнэ. Батчимэг гишүүнийг оруулаарай. Батчимэг гишүүнээр тасаллаа. Цогтгэрэл гишүүн. Асуулт, үг тусдаа шүү. Дараа нь үг байгаа.

О.Цогтгэрэл: Гишүүддээ ээлжит хаврын чуулганы мэндийг хүргэе. Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийн биелэлтийн тайлангууд орж ирж байна. Эндээс нэг цөөн ганц, 2 зүйлийг л тодруулаад асууя. Сая энэ тайланд хэлж байгаагаар 4 зүйлээс хамгийн өндөр нь буюу хүний эрхийг дээдэлсэн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт хамгийн өндөр оноотой хэрэгжсэн 40 хувь гэж сая танилцуулж байна л даа. Энэ дээр харагдаж байна 40 хувь. Зөвхөн энэ асуудлыг энэ хувь процент энэ хамгийн өндөр үр дүнтэй гэж байгаа хэрэгжилтийг аваад үзэхэд сүүлд гарч байгаа ОУБ-ын индексээр Монгол Улсын ардчиллын нөхцөл байдал ухралттай байна. Тоталитар, авторитар дэглэм рүү ухарч байна. Эдгээрийн үндсэн тэр хойш татаж байгаа үзүүлэлт нь төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдрэмж гэдэг зүйл Монгол Улс үүгээр хойш татаж байна гэдэг үзүүлэлт гарсан байна лээ 1 дүгээрт нь.

Тэгэхээр ОУБ ингэж үнэлж байдаг. Дөнгөж өнгөрсөн шөнө гэлүү ноорог.мн гээд сайт руу төрийн байгууллага, хуулийн байгууллагын зүгээс тэр прокурор энэ тэрнийхээ зөвшөөрөлтэй юм уу, үгүй юм уу, хойшлуулшгүй ажиллагааг хийгээд л яваад л баривчлаад л явж байдаг. Энэ бүх нөхцөл, гадаад, дотоод үнэлгээ, нөхцөл байдал чинь ийм байдаг. ЗГ үйл ажиллагааны тэр 4 зүйлийн багцынхаа хамгийн өндөр хэрэгжилттэй хүний эрхийг дээдэлсэн бодлого чиглэлийн үйл ажиллагаа маань хамгийн өндөр хэрэгжилттэй сайн хэрэгжилттэй байгаа гэж байна 1 дүгээрт нь. Тэгээд энэ бүхэн дээр яагаад бодит байдал үнэлгээ дүгнэлт хоёр ийм хоорондоо хол зөрөө байгаад байгаа юм бэ? Аль эсвэл бусад нь ийм муу байгаа юм уу? Энэ дээр 1 дүгээрт нэг тайлбар өгөөч.

2 дугаарт нь энэ эдийн засгийн нөхцөл байдлыг энэ 25 оны нөхцөл байдлыг больё. Энэ чинь өнгөрсөн хугацааны хэрэгжилт ярьж байгаа. 24 оноор ингээд үзэхээр сүүлийн 8 жилийн тоог харахад 8 жилийн өмнө бизнес регистрт бүртгэлтэй ААН-үүдийн 50 гаруй хувь нь үйл ажиллагаагаа байнгын явуулдаг байж Монгол Улсад эдийн засгийн хувьд. Өнөөдөр бүртгэлтэй ААН-үүдийн 40 хүрэхгүй хувь нь үйл ажиллагаа явуулдаг болчихож. Бизнесийн байгууллагуудыг. Яагаад бүртгэлтэй ААН-үүдийн ингэж үйл ажиллагаа явуулж байгаа, явуулахгүй байгаа тоо хэмжээ ингэж ихээр өсөөд байгаа юм бэ? Энэний цаана ямар бодлогын үйл ажиллагааны дутмагшил байна гэж дүгнэдэг юм бэ? Энэ ингээд тодорхой байгаа л тоонууд. Бүртгэлтэй ААН-үүд үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа хувь хэмжээ нь эдийн засаг сайн байгаа, макро эдийн засгийн нөхцөл сайн байгаа гэж байгаа өнгөрсөн жилүүдэд ерөөсөө энэ хувийн хэвшлийн оролцоо ингээд буураад байгаа юм бол? Энэ Засгийн газар үйл ажиллагааны хэрэгжилт болоод өнгөрсөн 21 оноос нааших үндсэн чиглэлийн тухай ярьж байна, 24 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай ярьж байна. Тэгэхээр энэ 2 дээр нэг тодруулга хариулт.

Ц.Сандаг-Очир: Цогтгэрэл гишүүний асуултад хэн хариулах вэ? Доржханд сайд.

Т.Доржханд: Баярлалаа. Энэ Цогтгэрэл гишүүний тавьж байгаа асуултад манай энэ Хууль зүйн яам, тэгээд Сангийн яамны хүмүүс маань бэлдэж байгаарай.

Тэгэхээр энэ нөгөө өнгөрсөн 4 жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг бол товч танилцуулсан байгаа. Тэгээд дэлгэрэнгүйг нь манай ажлын хэсгийнхэн тоон үзүүлэлтүүдээр нь гаргаад тэгээд тайлбарлах юм. Хүний эрхтэй холбоотой асуудал дээр би тантай санал нэг байна л даа. Тэгээд яг энэ асуудлаар тухайлбал Хууль зүйн сайдаас тодруулга авсан. Тэгээд мэдээллийн зөрөө байх шиг байна, ЦЕГ-аас мэдээллээ өгье гээд тэгсэн байгаа. Тэгээд олон улсын ер нь олон улсын хөндлөнгийн үнэлгээнүүд бодитой үнэлгээнүүд байдаг. Засгийн газар дээр энэ жилээс эхлээд олон улсын яг хөндлөнгийн үнэлгээнүүдийг үр дүнгүүдийг нь сайжруулах чиглэлээр түүн дээр суурилсан бодлогуудаа авч хэрэгжүүлье гэж бид нар бол тохирсон байгаа.

Эдийн засгийн нөхцөл байдлын хувьд өнгөрсөн 4 жилийн хугацаанд маш олон ийм гадаад, дотоодын таагүй орчнууд үүссэн нь бодитой. Тэгээд яг энэ чиглэлээр зүгээр хамтарсан Засгийн газар хувьд бид нар энэ хаврын чуулганаар яг бизнесийн орчныг таатай болгох зорилгоор татварын багц хуулийн төслийг 10 жилийн дараа анх удаагаа оруулж ирэхээр, гадаадын хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой байлгахыг оруулж ирэхээр, мөн нийгмийн даатгалын багц хуулийн төслийг параметрийн өөрчлөлттэй нь оруулж ирэхээр ингээд хүлээгдэж байгаа. Засгийн газар түвшинд ажлын хэсэг гараад Улсын Их Хурлын түвшинд мөн адилхан ажлын хэсэг гараад ингээд хаврын чуулганаар орох юм. Тэгээд эдгээр асуудлууд шийдэгдсэний дараа энэ хувийн сектор ялангуяа дотоодын гэлтгүй гадаадын хөрөнгө оруулалтын орчин сайжирна гэсэн ийм хүлээлттэй байгаа гэдгийг мэдэгдмээр байна. Тэгээд Цогтгэрэл даргын энэ яг өмнөх тайлантай холбоотой 2 асуудлаар Хууль зүйн яамны ТНБД болоод, Сангийн яамны ТНБД нар мэдээлэл өгнө үү. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Цогтгэрэл гишүүний асуултад Хууль зүйн сайд Алтангэрэл сайд хариулна. Сангийн яамнаас хэн байна вэ? Дараа нь хариулахад бэлдэж байгаарай.

О.Алтангэрэл: Цогтгэрэл гишүүний асуултыг сонссонгүй. Тэгээд өнөөдөр би энэ Байнгын хорооны гишүүний хувиар хуралд оролцож байгаа юм. Тэгээд хэрвээ сонссон бол манай Мягмар даргад хариулчих уу?

Ц.Сандаг-Очир: Хууль зүйн яамны ТНБД Мягмар дарга 1 номерын микрофоныг өгье.

Н.Мягмар: ХЗДХЯ-ны ТНБД Мягмар. Цогтгэрэл гишүүний хүний эрхтэй холбоотой асуудалтай холбогдуулж асуултад хариулъя. Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөө, Монгол Улсыг хөгжүүлэх 24 оны хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл зэргээр ХЗДХЯ-ны салбарын хүрээнд төлөвлөгөө гаргаж ажилласан. Энэ хүрээндээ ялангуяа хүний эрхийг хангах чиглэлд хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд хууль тогтоомжуудыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж өмнөх Улсын Их Хурлууд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжууд байж байгаа. Тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүх байгуулах тухай хууль, Гэр бүл, хүүхдийн хялбар ажиллагааны тусгай шүүх байгуулах хуулиуд батлагдсан энэ тэр гээд. Мөн хойшлуулшгүйгээр баривчлахтай холбоотой зохицуулалтыг мөн ЭХХШТХ-д өөрчлөлтийг оруулж энэ шүүхийн зөвшөөрөлгүй баривчилдаг энэ хугацааг багасгаж өгөх гэх мэт хууль, эрх зүйн орчныг хүний эрхийг хангах чиглэлд арга хэмжээ авч хуулиар батлуулсан.

Мөн Засгийн газрын 2024-өөс 2028 оны хөтөлбөрт тусгасны дагуу хүний эрхийг хангах чиглэлд хуулиас давсан зохицуулалтуудыг хуульд тусгах зорилгоор хүний эрхийг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хуулийн төсөл, зарим хуулиудад оруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өнгөрсөн онд өргөн мэдүүлчихсэн байж байна. Мөн Жагсаал цуглаан хийх журмын тухай, мөн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, мөн энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах өөрчлөлт гэх мэт 3 төрлийн багц хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн энэ хаврын чуулганаар хэлэлцүүлэх хуваарьт орно гэж ингэж.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Сангийн яам ТНБД Ганбат дарга 1 номерын микрофон дээр.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. 2023 оны жилийн эцсийн тоогоор нийт 160909 ААН үйл ажиллагаа явуулж байгаа бүртгэлтэй байгаагаас үүнээс яг Х тайлан гаргадаг ААН нь жишээ нь 20 онд 70432 байсан бол 23 оны жилийн эцсээр 66891 болж 7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 20 онд нийт энэ 160 мянган ААН-ээс 20 онд 42777 ААН нь ашигтай ажиллаж байсан бол 2023 оны жилийн эцсээр 61692 ААН ашигтай ажиллаж ингээд ашигтай ажиллаж байгаа ААН-ийн тоо 10 хувиар өссөн байна. 24 оны жилийн эцсээрх тоо одоо яг нэгтгэгдэж байгаа учраас яг эцэслэж хараахан гараагүй байна.

Ц.Сандаг-Очир: 1 үү? Тодруулъя Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ асуулт, хариулт 2-т дэндүү хол зөрөөд байна л даа. Ямар ч, юу ч хариулаад байгаа юм бүү мэд, асуусан асуулт их л хол зөрөөд байна. Зүгээр л хэрэгжилтийн үнэлгээ, бодит байдал 2 чинь ийм их зөрчөөд байна шүү дээ энэ дээрээ ямар дүгнэлт хэлж болох юм бэ л гэсэн. Түүн дээр шал өөр зүйлүүд л яригдаж байна. Тэгээд дахиад тодруулах боломжууд гарах биз. Доржханд сайдад энэ эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой нэг хэдэн тоог хэлэхэд манай эдийн засаг өсөж байна гэдэг. Энэний цаана яг ямар бодит байдал байна гэхээр төртэй холбоотой, төрийн өмчит ААН-тэй холбоотой нийлбэр бараг эдийн засгийнхаа 70 хувьд хүрчихсэн, үлдэж байгаа 30 хувьд нь хувийн ААН-үүд энэнийх нь бараг топ 100 ААН гэдэг нь энэнийх нь бараг 90-ээд хувийг нь эзэлдэг. Энэний цаана чинь жижиг, дунд ААН-үүдийнх нь оролцоо энэ эдийн засагт байхгүй болчихсон. Топ 100 аж ахуйн нэгжийг нь бараг банк санхүү, харилцаа холбоо, уул уурхай гээд бүгд лицензээр ажлаа хийдэг компаниуд л үлдчихсэн. Тусгай зөвшөөрлөөр.

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд, Цогтгэрэл гишүүн гүйцээгээд.

О.Цогтгэрэл: Ерөөсөө л өнгөрсөн хугацааны эдийн засгийн бодлогын алдаа миний хувьд энд байна л гэж боддог. Эдийн засаг тодорхой хэмжээгээр томорсон уу томорсон, төр, төрийн өмчит ААН-үүд дийлэнхийн дийлэнх болчихсон. Тоо том байдаг, хувийн ААН-үүд тэр тусмаа жижиг, дунд ААН-үүд чинь оролцоо байхгүй болоод хувирчихсан. Та нар хараарай тэр Топ 100 ААН-үүд чинь 1 дүгээрт нь эдийн засгийн дийлэнх хувийг эзэлж байгаа. Тэр чинь уул уурхай лицензээр, харилцаа холбоо лицензээр, банк, санхүү лицензээр бүгд төртэй холбоотой тусгай зөвшөөрлийн бизнесүүд энэ хувийн орон зайг чинь эзэлчихсэн. Тэгэхээр энэний цаана л яг ийм саяын тэр бизнес регистрт ААН-үүд эдийн засагт таатай байна гэж

байхад улам л хумигдаад байгаа. Энд л бид нар энэ бодлогын алдаагаа засаж цааш цаашид явахгүй бол одоо 25 онд эдийн засаг улам хүндэрч байна гэж байна. Гадаад орчин нөхцөл байдалд хүндэрч байна. Улам энэ чинь тийм шокийн байдалтай ирэхэд бэлэн ийм хувийн хэвшил чинь энэний цаана зогсож байгаа шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

Ц.Сандаг-Очир: Сайд нар гишүүдийн асуултад бүгд хариулна шүү. ЗГ-аас ирүүлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бүх сайд нар орсон байгаа. Тийм учраас та наад асуудлаа эрхэлсэн сайд хийж байгаа бол наад салбарын асуудалд гишүүдийн асуултад хариулах үүрэгтэй шүү. Тийм учраас доод албан тушаалтнууд руу хиймээргүй байна гэдгийг хэлье. Дараагийн гишүүн Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Монгол Улсын 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тайлан орж ирж байна. Тэгэхээр бид нар анх удаагаа 5 жилийн үндсэн тайлангаа хэлэлцэх гэж байна. Яг одоогоос 5 жилийн өмнө Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 батлагдаж байсан. Энэ бодлого батлагдсанаараа бид нар үндсэн чиглэлээ ганцхан жилээр явдаг байсан үндсэн чиглэлээ бид нар 5 жил болгож байсан. 5 жил тутам бид нар бодлогоо, төлөвлөлтөө хий, энэнийхээ тайлангаа Улсын Их Хуралдаа Засгийн газар нь тайлагнаж гэж. Тэгэхээр тэр утгаараа энэ бид бүхний анхны 5 жилийн үндсэн чиглэлийн тайлан орж ирж байгаа. Тэр урт хугацааны хөгжлийн бодлого батлагдахад нэг гарсан томоохон реформын шинж чанартай зүйл Засгийн газар тогтолцоо дээр гарсан. Энэ бол Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулах байсан. Эдийн засаг хөгжлийн яамны сайд нь Тэргүүн шадар сайдын хэмжээнд байх ёстой юм байна гээд. Тэгэхээр өнөөдрийн бидний хэлэлцэж байгаа энэ 5 жилийн үндсэн чиглэл ерөөсөө л Эдийн засаг, хөгжлийн сайдын хамгийн гол үндсэн ажил нь. Энийгээ Улсын Их Хурал дээр тайлагнаж гэж байна гэж ойлгож байгаа.

Гэтэл өнөөдөр Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн шадар сайд байхгүй байна. Миний асуултууд дандаа Эдийн засаг, хөгжлийн сайд руу чиглэсэн байсан. Энэ тайланг яг өөрөө хамгаалж, Улсын Их Хурал дээр гарах ёстой гол субъект бол өөрөө Гантөмөр сайд. Өнөөдөр яагаад Гантөмөр сайд ирээгүй юм бэ? Энэ зөвхөн Гантөмөр сайд биш энэ буцаад Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 5 жилдээ хэрэгжиж, Улсын Их Хуралдаа тайлагнаж байна гэсэн маш том агуулга явж байгаа шүү дээ. Тэгэхээр хариуцаж байгаа сайд нь өөрөө ирээгүй байна. Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн чиглэлийг та нарт уншиж өгье. Монгол Улсын урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй яам байхгүй юу. Тэгэхээр энэ бүх бодлогыг нэгтгэж, зангидах нэг яам зайлшгүй байх ёстой юм байна тэр нь Эдийн засаг, хөгжлийн яам Тэргүүн шадар сайдын хэмжээнд байх ёстой юм байна гэж. Тэгэхээр 5 жилийн анхны тайлангаа бид нар ингээд ярьж байхад сайд нь өөрөө байхгүй байх нь маш буруу л гэж ойлгож байна.

Тэгээд энэ дээр 2 асуулт байна. Даргаа минутаа сунгаад авчихъя. Чиг үүргээ гүйцэтгэлийн тайлан дээр гарсан байна л даа аудитын тайлан дээр. Чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй гэж маш олон дурдагдсан байна. Тэр дундаа Эдийн засаг, хөгжлийн яам энэ хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлийнхээ боловсруулах хууль тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй. Тэгээд түүний хэрэгжилт дээр нь ЗГХЭГ луу нэгтгэн боловсруулахаар тогтсон гэсэн тайлбар өгсөн гэж байх юм.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Батнайрамдал гишүүн нэмэлт 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас өмнө нь ЗГХЭГ-ын ЗГХЭГ нэг ёсондоо тайланг нэгтгэдэг байсан тийм ээ? Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамтай болсноор энэ Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн гол үүрэг шүү дээ. Тэгэхээр энэ дээр 1 дүгээрт тайлбар авмаар байна.

2 дугаарт энэ дээр нэг зүйл байгаа. Ер нь энэ 5 жилийн тайлан маань яг хэрэгжсэн үү, үгүй юү гэдэг дээр бас нэг хамгийн гол индикатор яг хэрэгжсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээ л юм л даа. Тэгэхээр нийт хэрэгжсэн төсөл, арга хэмжээг аваад үзвэл 34,6 хувь нь хэрэгжсэн гэж байгаа юм. Нэг ёсондоо 1/3 нь төсөл, арга хэмжээний хувьд хэрэгжсэн бусад нь 66 хувь нь хэрэгжээгүй. Тэгээд хэрэгжээгүй шалтгааныг энэ аудитынхан ингэж дүгнэсэн байна. 159 бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний 71 хувь нь буюу 113 нь шалтгаан нь ерөөсөө удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагаатай холбоотой шалгуур үзүүлэлт бүрэн түвшин оновчтой тогтоогоогүй гэж. Нэг ёсондоо санхүүжилтийн шийдвэрлэгдээгүй биш хоорондын уялдаа хангаагүй.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах юм бэ? Шадар сайд Доржханд дарга.

Т.Доржханд: Баярлалаа. Яг энэ 5 жилийн төлөвлөгөөтэй холбоотой тэгээд нэгтгэдэг ийм функц нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ирсэн. Энэ бол зүйтэй. Тэгээд энэ дээр би Батнайрамдал гишүүнтэй санал нэг байгаа. Тэгээд цаашаа яг ингээд нэгтгээд явдаг соёл руугаа орно. Нэг тайлбар хэлэхэд манай Тэргүүн шийдвэр шадар сайд албан томилолтоор Оросын Холбооны Улсад яаралтай ажлаар өнөөдөр ажлаар явсан байгаа, тэгээд 2 хоночхоод ирнэ. Энэ 3 дахь, 4 дэх гэхэд ирчих байх. Тэгээд ирээд өөрөө энэ асуудлаа оруулна. Тэгээд үүнийг бэлтгэсэн манай Эдийн засгийн хөгжлийн яамны ажлын аппарат байгаа ТНБД болон холбогдох газар, хэлтсийн албаных нь хүмүүс байгаа болохоор тэндээс мэдээлэл өгөх бүрэн боломжтой гэдгийг хэлье. Тэгээд Үндэсний аудитын газраас тайлбар өгөх юм байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү дарга 1 номерын микрофон дээр.

И.Батхүү: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Энэ 2021-ээс 25 оны 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл батлагдах үед Эдийн засаг, хөгжлийн яам тухайн үед байгаагүй. Таны хэлж байгаагаар сүүлд байгуулагдсан. Тухайн үед ЗГХЭГ, Үндэсний хөгжлийн газар гээд агентлаг оролцоод салбарын яамнууд, агентлагуудаас бодлогын санал, арга хэмжээнийхээ төслийг цуглуулаад тал талын оролцоог хангаад боловсруулж ажилласан гэж ойлгож байгаа. Яг одоогийн түвшинд бид нар Эдийн засаг, хөгжлийн яамнаас дараагийн цикл буюу энэ дараагийн 5 жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа энэ өнөөдөр яригдаж байгаа аудитын зөвлөмжүүд, гишүүдийн хэлж байгаа санал, дүгнэлт зөвлөмжийг анхаарч ажиллана. Энэ дээр манай яамны ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Ер нь манай яамнаас боловсруулж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг дунд, богино хугацааны одоо ажиллаж байгаа баримт бичгүүд дээрээ бүх яамнууд, агентлагууд, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагаас санал авч нээлттэй ажиллаж байгаа. Цаашдаа ч гэсэн энэ зарчмаа үргэлжлүүлж ажиллана.

Ц.Сандаг-Очир: Тодруулга 1 минут Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Тэгэхээр бид нар урт хугацааны хөгжлийн бодлого дээр ерөөсөө Эдийн засаг, хөгжлийн яам байгуулах гол шалтгаан л ерөөсөө хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хооронд нь уялдуулъя, уялдаа холбоог нь хангая, зохион байгуулалтаар нэгдсэн зохион байгуулалтад оруулъя. Тэгэхийн тулд энэ яамны сайд нь өөрөө Тэргүүн шадар сайдын хэмжээнд байх ёстой юм байна гэсэн гол агуулга явсан юм л даа. Гэтэл яг энэ аудитын дүгнэлт дээр бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний ерөөсөө 70 хувь нь тэгээд буцаад л яг удирдлага, зохион байгуулалт, уялдаа холбоо хангаагүй гэсэн шалтгаанаар хэрэгжээгүй байна л даа. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамтай болсноороо үр дүн нь гарсан уу, үгүй юу гэдэг яг энэ 5 жилийн төлөвлөгөө дээр л 5 жилийн гүйцэтгэлийн тайлан дээр гарч ирэх ёстой байхгүй. Тэгэхээр тэрний хэрэгжилт маань 70 хувь нь буцаад л нөгөө зохион байгуулалт, хоорондын уялдаа холбоо хангаагүй гэдэг нь буцаад Эдийн засаг, хөгжлийн яам тэгэхээр ажлаа хийсэн үү, үгүй юу гэдэг дээр хамгийн том асуултын тэмдэг гарч ирж байгаа юм. Тийм учраас энийг урт хугацааны хөгжлийн бодлого дээр бидний гол суулгасан тэр агуулгатай холбож л яриад байгаа юм л даа.

Ц.Сандаг-Очир: Батнайрамдал гишүүний асуултад аудитаас, хэн бэ, хэн нь хариулах юм бэ? Гараа өргөөрэй, 2 номерын микрофон, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Д.Энхболд: Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд. Аудитаар гарсан дүгнэлтийн хувьд Батнайрамдал гишүүн хэлчихлээ. Тэгэхээр ер нь төлөвлөлтийн оролцоог хангах асуудал хамгийн чухал байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагчид болон Засгийн газар дээр төлөвлөлтийн алдаа дээр гарч байгаа гол асуудал бол оролцоог хангах асуудал хангалтгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл тухайн хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлийг сайжруулна гэдэг асуудлыг ганцхан Хүнс, хөдөө аж ахуйн яамны асуудал юм шиг. Гэтэл энд нь Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, нийгмийн эрүүл мэнд, холбогдох яамнуудынх нь оролцоог хангахгүйгээр тухайн яамных нь хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг л тавьчихдаг. Хамтын ажиллагааны оролцоотой байгаа газруудынх нь ажлыг хамтад нь төлөвлөдөггүйгээс орхигдоод энэний хэрэгжилт бага гарах ийм асуудлууд байгаа. Энийг нь удирдан чиглүүлж эрэмбэлэх асуудал Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байгаа учраас энэ чиг үүргийнхээ ажлыг хуульд заасныхаа дагуу.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулах уу? 1 номерын микрофон. Эдийн засаг, хөгжлийн яам, тодорхой хариулаарай гишүүдийн асуултад.

И.Батхүү: Түрүүчийн хариултад би дурдсан байгаа. Эдийн засаг, хөгжлийн яамнаас яг одоо боловсруулж байгаа жилийн хөгжлийн төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл тэгээд өнгөрсөн намар боловсруулсан Засгийн газар үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр энэ бүх бодлогын баримт бичгүүд дээр манай яамнаас ажлын хэсэг гараад Засгийн газар холбогдох бусад яамнууд, агентлагууд бүгдтэй нь ингэж хамт бодлогын уялдааг хангаж боловсруулж ажилласан байгаа. Энэ талаар тухайн бодлогын тэргүүлэх чиглэл авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тухайн арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлтийн талаар тухай бүрд нь нөгөө холбогдох мэргэжлийн байгууллагуудаас тайлбар саналыг нь авч ажиллаж байсан. Одоо хийгдэж байгаа процесс дээр ч гэсэн энэ

үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа, манай яаман дээр холбогдох яамнуудын энэ бодлогын асуудлуудыг хоорондоо уулзалдаад уялдааг нь хангах тал дээр идэвхтэй ажиллаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Дараагийн гишүүн Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Аудитын газраас үнэлгээ хийх гэсэн аргачлалтай байдаг юм байна. Хэрэг эрхлэх газар тусдаа үнэлгээний аргачлалтай юм байна. Эдийн засгийн хөгжлийн яам тусдаа үнэлгээний аргачлалтай, хэрэгжүүлэгч байгууллага нь тусдаа үнэлгээний аргачлалтай ингээд 4 аргачлалаар л яваад байна л даа. Энэ Засгийн газар дээр энэ хийж хэрэгжүүлсэн тэр арга хэмжээ дээр холбоотойгоор үнэлгээ хийх аргачлалыг нь баталсан юм байдаг уу? Яг ямар аргачлалаар цөмөөрөө үнэлгээгээ хийх вэ гэдэг дээр. Энэ чинь ерөөсөө хол зөрөөтэй тоонууд яваад байгаа байхгүй юу. Амьдралын чанар ба дундаж давхарга хэрэгжүүлж байгаа газар нь 93 хувь гэсэн байгаа юм. Тэгэнгүүт Эдийн засгийн хөгжлийн яам 82 хувьтай, Хэрэг эрхлэх газар 66 хувьтай, аудит болохоор дээш нь 71 хувь болгоод хаячихсан байгаа. Үндэсний нэгдмэл үнэт зүйл гээд хэрэгжүүлж байгаа байгууллага нь 94, Эдийн засгийн хөгжлийн яам 82 хувь, Хэрэг эрхлэх газар 51,9 хувь, Аудит 60 хувь гээд. Энэ нөгөө хоорондоо энэ чинь үнэлгээний аргачлал маань өөр өөрөөр хийлээ гэхэд нэг, хоёрхон тоогоор л зөрөх ёстой шүү дээ. Тэгээд энэ чинь ерөөсөө газар, тэнгэр шиг юмнууд байгаад байна шүү дээ.

Энийг харвал энэ хэрэгжүүлж байгаа газар нь өнөөдрийн манай амьдралын чанар, дундаж давхарга жигтэйхэн сайхан болчихсон юм шиг сайхан л тоотой ийм тайлан орж ирж байна. Засаглал 94 хувьтай гэсэн байна. Тэгсэн мөртөө Хэрэг эрхлэх газар нь 50 хувиар үнэлсэн байна. Аргачлалдаа байна уу эсвэл хариуцлага тооцохгүйдээ байна уу? Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийнхээ тоон үзүүлэлтээр харахаар 14-хөн хувь нь л үр дүнтэй болсон байна гэдэг ийм тоо танилцуулж байдаг. Тэгэхээр өнөөдөр энэ Батнайрамдалын яриад байгаа зөв л дөө. Шадар сайд бол хөгжлийн төлөвлөгөөгөө нэг танилцуулж нэг өөрөө танилцуулж орж ирэх ёстой, тайлангаа өөрөө хамгаалах ёстой. Тэгээд энэ тайлан нь харахаар өөрөө эргээд энэ чинь асар том хоорондоо зөрөөтэй 90-ээс, 94-өөс 50 хувийн хооронд, нэг ёсондоо 40 хэдэн хувиар хоорондоо зөрөөтэй тоонууд явж байгаа байхгүй юу. Тэгээд бид нар яг аль тоог нь бариад, ямар хэмжээний гүйцэтгэлтэй ажилласан гэдэг дүгнэлт хийх юм бэ? 14-хөн хувь нь амжилттай үр дүнтэй болсон байна гэсэн байна, 243 төсөл байна. Тэгээд энэ чинь нэг ёсондоо юу гэсэн үг вэ гэхээр бид нар ямар ч үр дүнгүй юм руу баахан мөнгө цацаад, тэгээд өөрөө өөрсдийгөө болохоор 90 хэдэн хувиар үнэлээд тэгээд л ингээд сууж байдаг л болох гээд байна шүү дээ. Энэ чинь 20, өмнөх юугаар чинь харвал 27 их наяд төгрөгийн үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа байхгүй юу. Тэгээд тэрний 14 хувиар цөмөөрөө бодоод.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах юм бэ? Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга, сайд Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хуулиар Эдийн засгийн хөгжлийн яам энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээрээс нь жилийн төлөвлөгөө Их Хуралд оруулж ирж, цаашлаад энэ гүйцэтгэлийн

аудитын тайланг ч гэсэн хамгаалж гарах ийм үүрэгтэй. Энэ утгаараа Эдийн засгийн хөгжлийн яамны зүгээс өнөөдөр энэ мэдээллүүдийг бэлтгэсэн гэж ойлгож болно.

Тэгээд ер нь энэ хавар бид энэ нийтийн албаны энэ реформыг хийх, цаашлаад ер нь Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүн, энэ тогтолцооны хувьд өөрчлөлт хийхгүй бол ийм гажуудалд ер нь хүрчихсэн юм байна лээ. Тэгэхээр энэ юу вэ гэхээр жишээ нь Хяналт хэрэгжүүлэх газар гэж газар байна. Өнгөрсөн Засгийн газар үед Хяналт хэрэгжүүлэх хууль батлагдсан. Хяналт хэрэгжүүлэх хууль батлагдах үед ЗГХЭГ-ын дэргэд энэ Хяналт хэрэгжүүлэх газар ажилладаг байсан. Одоо бол бие даасан сайдтай бие даасан агентлаг. Тэгэхээр ЗГХЭГ хяналт үнэлгээ хийх хуулийн боломж байхгүй болчихсон. Гэхдээ Засгийн газрын хуралдаанд оруулах үүргийг хүлээдэг. Нэг ёсондоо хянагдаад ирсэн материалуудыг нь Засгийн газарт оруулж байгаа болохоос биш яг хяналт хэрэгжүүлж байгаа ажил бол Хяналт хэрэгжүүлэх газар хийгдэж байгаа тийм биз. Тэгэхээр энэ Хяналт хэрэгжүүлэх газраас хүмүүс ирчихсэн байх шиг байна. Ингээд энэ үнэлгээний аргачлалыг Засгийн газраар бид нар баталсан. Үнэлгээний аргачлал гээд. Энэ аргачлалын дагуу яам болгон өөр өөрсдийгөө, энэ агентлаг болгон өөр өөрсдийгөө үнэлдэг. Энэ аргачлалыг барьж байгаад.

Тэгэхээр энэ зөрөөтэй гараад байна гэдэг бол зарим байгууллагууд өөрсдийгөө хэт их өндөр үнэлсэн байна, зарим нь их бодит байдалтай нийцүүлсэн байна ч гэдэг юм уу. Яг энэ үнэлгээний аргачлалын дагуу хийгдсэн. Энэ үнэлгээнүүд нэгдээд Хяналт хэрэгжүүлэх газар дээрээс нэгтгэгдэж байгаа гэсэн үг. Тэгэхээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар бол энэ ажлыг одоо хариуцаж байна. Гэхдээ мэдээж салбарын яамнууд өөр өөрсдийн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд ажлуудаа ингээд үнэлээд явдаг. Энэ нь өөрөө Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрүүд дээр тусгагдсан ажлуудыг хэрхэн хэрэгжүүлсэн бэ, дээрээс нь жилийн төлөвлөгөөний энэ зорилт болгон дээр ингээд үнэлгээнүүд тавигдаад явж байгаа. Тэгэхээр энэ үнэлгээ ингээд зөрөөтэй гараад байгаа бол одоо зүгээр нэг хувийн нэг ААН-үүд бараг ихэнх нь гүйцэтгэлийн үнэлгээг 360 градусаар энэ тэр хийдэг болчихлоо л доо. Бид болохоор ингээд өөрсдийгөө их өндөр үнэлж тавьчихаад бид их мундаг ажилласан гээд суугаад байж болохгүй л дээ. Тийм учраас үнэлгээгээ шинэчил, үнэлгээний аргачлалаа шинээр оруулж ир гэдэг ийм л шаардлагыг бид нар тавьж байгаа юм.

Тийм учраас энэ үнэлгээнийхээ аргачлалыг шинээр бид нар батлаад, энэ 360 градусын ядаж үнэлгээний аргачлалыг оруулж ирж байж нөгөө төрийн дунд ч бай, удирдах албан тушаалд ч бай бүх түвшинд үнэлээд, түүний дунджийг олдог энэ тогтолцоо руу шилжихгүй бол ингээд өөрсдийнхөө ажлыг ингээд сайн хийчихсэн юм шиг ингээд үнэлээд байх нь зохимжгүй байгаад байгаа юм. Тийм учраас энэ хавар бид нар энэ төрийн албаны шинэчлэл цаашлаад энэ тогтолцооны өөрчлөлтийг хийхээс өөр ер нь арга замгүй. Тийм учраас Батнайрамдал гишүүний хэлээд байгаа бол үнэн. ЗГХЭГ Засгийн газар хуралдаанд оруулах материалуудыг хянаад, нэгтгээд оруулж байгаа учраас үүнд оролцож байгаа болохоос биш яг үнэлгээ хийх, мониторинг хийх хэсэг бол бие даасан агентлаг дээр ингээд явж байгаа. Тэгэхээр бид хоорондоо л ингэж уялдаж ажиллаж байна л гэсэн үг л дээ. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яам энэ хөтөлбөрөө, төлөвлөгөөгөө боловсруулаад, үүнийгээ шахаж шаардаад ингээд хөндлөнгөөс Хяналт хэрэгжүүлэх газар нь үнэлээд явдаг одоо ийм тогтолцоо л үйлчилж байна гэж ойлгож болно.

Ц.Сандаг-Очир: Ганхуяг гишүүн нэмэлт тодруулга 1 минут.

Х.Ганхуяг: Ерөөсөө зарчмын санал гаргамаар байна. 1 дүгээр асуудал энэ үнэлгээтэй холбоотой асуудлуудаа нэг тийш нь болгомоор байна. Бид нар энэ сайд нарт үнэлгээ өгөх цорын ганц баримт бол энэ. Тэгсэн мөртөө дүнгүүд нь энд хоорондоо 10, 10, 10 гээд л бараг 40 хэдэн хувиар зөрөөтэй. Өөртөө өгч байгаа дүн, аудитаас өгч байгаа дүн, Хэрэг эрхлэхээс өгч байгаа дүн хоорондоо 10, 10 хувийн зөрөөтэй. Бид нар сайд нар дээр дүн тавих цорын ганц бичиг баримт энэ байхгүй юу. Бид нар төсвөөр дүн тавихгүй, хөгжлийн төлөвлөгөөгөөр дүн тавихгүй. Харин хөгжлийн төлөвлөгөөг нь баталж өгөөд, гүйцэтгэлийн тайлангаар л бид нар дүн тавина. Тэгээд сайд нь байхгүй. Хоорондоо хийсэн үнэлгээнийх нь зарчим нь гол зарчмын асуудал нь хоорондоо зөрөөтэй. Тэгээд ийм байхад бид нар энэнийг хэлэлцэнэ гэж юу байх вэ дээ. Нэг бол тэр Шадар сайд нь ирснийхээ дараа энэ хурлаа зарлаж хуралдуулах ёстой юм уу? Энийг нэг тийш нь шийдсэн нь зөв байх Сандаг-Очир даргаа.

Ц.Сандаг-Очир: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөө дээрээ тухайн яам, тухайн агентлаг үнэлгээгээ хийгээд яг тэр арга Засгийн газраас баталсан үнэлгээний дагуу үнэлгээгээ хийгээд, тэр үнэлгээ хийсэн тайланг нь Хяналт хэрэгжүүлэх газар дахиад үнэлж байгаа шүү дээ. Тийм. Тэгэхээр бас энэ чинь хянагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр Хяналт хэрэгжүүлэх газар үнэлээд, тэгээд ингээд эцэслэж оруулж ирж байгаа гэсэн үг. Одоо бол хуулийн хүрээнд, нөгөө хуулиар байгаа боломж нь энэ л дээ. Тэгээд хэрвээ Засгийн газар дээр оруулж ирээд танилцуулах бол үнэлгээнийхээ нөхцөл байдлуудыг танилцуулах бол unelgee.gov.mn дээр тавигдаж байгаа мэдээллүүд манай Засгийн газрын dashboard дээр нэгтгэгдэх энэ тэр дээр бол ЗГХЭГ өнөөдөр орох хуулийн боломж байгаа болохоос биш бид үнэлж чадахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр Хяналт хэрэгжүүлэх газар энэ яаж үнэлснээ яриач.

Ц.Сандаг-Очир: Ганхуяг гишүүний асуултад ажлын хэсгийн 4 дүгээр микрофон, дараа нь 3 дугаар микрофон. Албан тушаалаа хэлээд танилцуулаарай. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Д.Үүрийнтуяа: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд болоод Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн амрыг эрье. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын дарга Үүрийнтуяа байна. Би бас нөгөө микрофон олдсон дээр түрүүн Цогтгэрэл гишүүний асуусан асуулт ер нь нөгөө гишүүдийн асууж байгаа асуулт дээр нэг жоохон тодорхой ойлголтуудыг өгөх ёстой байх гэж бодож байна. Түрүүн үйл ажиллагааны хөтөлбөрийн 24-өөс 28 онд батлагдсан энэ хэрэгжүүлэх Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийн зөвхөн 8 сард батлагдсан байгаа. 8 сараас 12 сар хүртэлх бид нар энэ үйл ажиллагааг үнэлээд, энэ жилийнх нь танилцуулагдаж байгаа. Тэрнээс биш өнгөрсөн 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр биш юм гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ хөтөлбөрийн үйл ажиллагаа маань энэ Засгийн газар 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн маань эхлэл бол яг энэ сая 8 сараас 12 сар хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг бид нар үнэлгээг нь танилцуулсан.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд Тамгын газраас нэмэлт тайлбар өгье гэж байна. ЗГХЭГ-ын дэд дарга Амарбат ажлын хэсгийн 9 дүгээр микрофон. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ү.Амарбат: Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээ, мониторинг хариуцсан дэд дарга Амарбат байна. Ганхуяг гишүүний асуултад нэмж тодруулж хариулья. Сая гишүүний хэлсэнчлэн бидний хувьд яг энэ шалгуур үзүүлэлт юуг үндэслэж үнэлэх вэ гэдэг дээр үнэхээр яг том асуудал тулгарчхаад байгаа нь бол үнэн. Яагаад гэвэл анхны үнэлгээ хийж байгаа байгууллагууд илүү нөгөө арга хэмжээгээ хэрэгжсэн эсэхээр үнэлгээ ирүүлж байгаа. Ингэхээр тухайн зорилтод хүрэхийн тулд 20 арга хэмжээ, 30 арга хэмжээ төлөвлөсөн бол тэд нарыгаа хийчихээр 70, 80, 90 хувийн гүйцэтгэл гараад ирж байгаа. Тэгэнгүүт Засгийн газрын түвшинд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын түвшинд энэ арга хэмжээ өөрөө үр нөлөөтэй байсан уу, үгүй юү гээд ингээд үнэлэхээр нөгөө 90 хувийн маань арга хэмжээгээ биш, үр нөлөөгөө үнэлэхээр 90 хувь маань 40, 50 хувь руу буугаад буугаад ирж байгаа.

Энэ жилээс Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж өгч байгаа. Засгийн газраас орж ирж байгаа 50 хувь маань Улсын Их Хурлын Тамгын газар илүү үр дүнг үнэлж байгаа. Үр дүнг үнэлэхээр дахиад 10 функтээр буугаад 40 хувь дээр очиж байгаа. Тэгэхээр нөгөө арга хэмжээгээ үнэлэх үү, үр нөлөөгөө үнэлэх үү, үр дүнгээ үнэлэх үү гэдэг энэ зөрөө маань өөрөө энэ олон функтийн агуулгын зөрөөг үүсгэж байгаа. Гэхдээ ер нь олон улсын хандлага өөрөө илүү үр дүнгээ үнэлж байгаа. Тухайн арга хэмжээ хэдий хийгдсэн, ямар төсөв зарцуулагдсан гэдэгтээ биш энэ рүүгээ явах ийм агуулгатай. Хяналт шалгалтын тухай шинээр 2024 оны 5 дугаар сард батлагдсан хуулиар Их Хурал өөрийнхөө үнэлгээг Их Хурлын даргын баталсан аргачлалаар хийх ёстой гэдэг ийм хуулийн боломж гарч ирсэн байгаа. Энд илүү үр дүнд суурилсан үнэлгээгээ хийнэ гэдэг ийм зарчмын агуулга явж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Ганхуяг гишүүн нэмэлт 1.

Х.Ганхуяг: Амарбатаа би Их Хурлын хяналт шалгалт, шалгуур үзүүлэлтийн тухай юу ч асуугаагүй. Бид нар энд Засгийн газрын 21-ээс 25 оны хоорондох үйл ажиллагааны үндсэн чиглэлийн юугаа л ярилцаж байгаа. Та тэнд сүүлийн 8 сар гээд байгаа энэ ажлаа мэдэхгүй бол ажлаа эртхэн шиг өг, эртхэн шиг танд сануулъя. Тэгээд би юу хэлээд байна гэхээр нийт энэ хэрэгжүүлсэн 243 арга хэмжээний чинь 36-хан л хэрэгжсэн байна гэж байгаа юм, 14-хөн хувь нь. Тэгээд миний үнэлгээгээр энэ чинь 14 хувийн л хэрэгжилттэй байгаа байхгүй юу. Тэгэнгүүт та нар болохоор чинь ингээд 90 хэдэн хувь, тэгэнгүүтээ Хэрэг эрхлэх газар болохоор 50 хувь, аудит болохоор 60 хэдэн хувь гээд үнэлчихсэн байж байгаа байхгүй юу. Энэ яаж та нар энийгээ үнэлээд байгаа юм бэ? Тэрийгээ нэг тодорхой хэлээч гэнгүүт нь Их Хурлын хяналт шалгалтын хүн гарч ирээд л бид өөрийгөө тайлбарлаад суугаад байгаа юм. Энэ чинь Их Хуралтай холбоотой юу ч байхгүй дарга. Та асуудлаа мэдэхгүй бол асуудал мэддэг наад Аудитын газраас.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Я.Самбууням: Ерөнхий аудитын орлогч Самбууням байна. Ганхуяг гишүүний асуултад хариулья. Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2021-

ээс 25 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн үнэлгээг хэрэгжүүлэхдээ цаг хугацааных нь нэгдсэн дүнгээр нь буюу нэгд хэрэгжсэн хугацаагаар нь үнэлсэн байгаа. Яагаад энэ үнэлгээний зөрөө гараад байна вэ гэхээр зэрэг Хяналт шалгалтын, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.1, 18.3.4-д нэгдсэн дүнгээр үнэлнэ гэхчхэн байгаа. Гэтэл энэ үнэлгээ хийж байгаа газрууд маань тухайн жилийнх нь хэрэгжилтээр нь 1 дүгээрт үнэлээд байна, 2 дугаарт нь нотлох баримтад суурилж үнэлэхгүй байна, 3 дугаарт нь хяналт шалгалт хийж байгаа хугацаа богино байгаагаас энэ үнэлгээний зөрөөнүүд гараад байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ үнэлгээний зөрөөг бол, иймээс үнэлгээний зөрөө үүсээд байна гэж дүгнэж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Пүрэвдорж гишүүн хурал зүгээр явуул. Ажлын хэсгийн 4 дэх микрофон.

Д.Үүрийнтуяа: Тэгэхээр Ганхуяг гишүүний асуултад би нөгөө өөр гишүүний асуултад хариулаад явчихаар ойлгогдоогүй байх. Ер нь бол өнөөдөр түрүүн Учрал сайд хэлсэн 206 дугаар тогтоолоор бүх төрийн байгууллагууд энэ тайлангуудаа гаргаж байгаа. Гэхдээ тэр манай гаргасан тайлангууд хамгийн түрүүнд бусад яамнуудын тайлангууд Эдийн засгийн хөгжлийн яам дээр нэгтгэгдээд, Эдийн засгийн хөгжлийн яамнаас манай газарт нэгтгэгдээд ингээд манайх эцсийн үнэлгээг өгдөг. Энэ үнэлгээ дээр бол аудит нийцлийн аудит хийгдээд, ингээд өнөөдөр энэ тайлангаа оруулж ирээд явж байгаа. Ер нь энэ 206 дугаар тогтоолоор маш их олон асуудлууд үүсэж байгаа учраас бид нар энэ 206 дугаар тогтоолыг Үнэлгээ хийх нийтлэг журам, Мониторинг хийх нийтлэг журам, Төрийн байгууллагын захиргааны байгууллагыг үнэлэх журам гээд тусад нь 3 журам гаргаж байгаа. Монгол Улс өнөөдөр бодлогын үнэлгээ хийгддэг нэг ч юм байдаггүй, дандаа мониторинг хийгдэж ирсэн. Тэгэхээр энэ мониторинг маань түрүүн хэллээ ихэнхдээ нөгөө дандаа үйл ажиллагаа, арга хэмжээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн микрофоныг өгье асуултаа асууя.

Б.Баярбаатар: Өдрийн мэнд хүргэе. Нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг чинь л энэ дээ. Хууль хэрэгжүүлэхийн тулд бид нар ингэж хуралдаж энэ асуудлыг ярих цагийн гарз юм биш үү. Тэгээд Байнгын хорооноос илүү чухал хурал аудитын даргад байдаг юм байна. Тэр Одбаяр гэж сайд чинь хаана байгаа юм бэ? Тэр Хяналт хэрэгжүүлэх сайд гээд томилогдоод хэдэн сарын хугацаа болчихлоо. Юу хийсэн юм бэ наад хүн чинь ер нь? Тэгээд нэг ийм гөлөг төөрүүлж байгаа юм шиг ийм хяналтын аймаар олон механизмтай, хариуцлагын асуудал энэ дээр нэг ч байдаггүй. Тэгээд тэр нь яасан энийг манайхан ингэж үнэлдэг юм, энийг манайхан ингэж үнэлдэг юм, тэр нь хэдэн функтээр явдаг юм гээд тэгээд л нэг хэдэн бие рүүгээ шидээд л. Их Хурлыг та нар арай ингэж болохгүй байх. Энэ чинь Монгол Улсын хууль тогтоох байгууллага шүү дээ. Тэгээд энэ дээр чинь ингээд хараад ингээд үзэхээр хар даа, энэ хар даа Пүрэвдорж даргаа байж байгаарай. Энэ дээр хар даа ингээд авлигын гэмт хэргийг бууруулна үр дүн 100 хувь ч гэж байх шиг. Би зүгээр ганцхан заалтыг нь л уншиж байна шүү. Авлигагүй болчихсон юм уу Монгол, гэмт хэрэг байхгүй болчихсон юм уу, 1 ч хэрэггүй болчихсон уу авлигын гэмт хэрэг? Тэгээд ийм юм танилцуулаад явж байхаасаа та нар ичих хэрэгтэй шүү дээ. Тэгээд цагийг нь тулгаж өгнө материалаа. Тэгээд Их Хурал 4 сарын 1-ний дотор энийг батлах үүрэгтэй ч гэж байх шиг. Бараг баталж чадахгүй бол та нар өөрсдөө хохь нь гэж байгаа юм уу, яаж байгаа юм. Хойшлуулъя, Сандаг-Очир даргаа энийг

хойшлуульъя. Тэр горимын санал оруулж байна санал хурааж өгнө үү? Хойшлуулах горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Энэ ийм байна. Хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд нам, эвслийн бүлгийн дарга хуралдаанаас завсарлага авах эрхтэй нэгд. 2-т, ер нь бол тийм л юм байна. Хойшлуулах, хойшлуулж болно. Хойшлуулах болно горимын санал гаргаж. 2 арга л байна. Хойшлуулах нэг арга байна. Нэг бол нам, эвслийн бүлгийн даргад завсарлага авах эрх байна. Нам, эвслийн бүлгийн даргад. 12 дугаар зүйлд хуралдаанаас завсарлага авах 12.1 энэ хуульд өөрөөр заагаагүй нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Нэг бол хойшлуулах. Орно шүү дээ, чуулганаар орно шүү дээ ирэх 7 хоногт. Ирэх 7 хоногт чуулганаар орно.

Баярбаатар гишүүн горимын санал гаргаж байна. Хуралдааныг Байнгын хорооны хуралдааныг хамтарсан хуралдааныг хойшлуулах санал гаргаж байна. Нэг бол одоо бүлгийн даргаас Цогтгэрэл дарга бүлгийн дарга байна, завсарлага авах эрхтэй, ийм л 2 арга байна. Ямар ч гэсэн горимын санал гаргасан учраас Баярбаатар дарга, гишүүний гаргасан горимын саналаар санал хураана. Дэмжигдвэл хуралдааныг хойшлуулна, дэмжигдэхгүй бол хуралдаан үргэлжилнэ гэсэн үг. Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар өнөөдрийн Байнгын хорооны хамтарсан хуралдааныг хойшлуульъя гэсэн горимын саналаар санал хураалт явуульъя. Санал хураалт. Горимын санал дэмжигдсэнгүй. Тийм учраас хуралдаан үргэлжлэхээр боллоо. Хуралдаанаа үргэлжлүүлъя. Горимын санал дэмжигдсэнгүй. Дараагийн асуулт, дараагийн гишүүн Лувсанжамц гишүүн асуултаа асууя. Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Өгсөнд баярлалаа. Өдрийн мэнд хүргэе.

Ц.Сандаг-Очир: Та нар өөрсдөө асуулт, санал хураалтад идэвхтэй оролц л доо, хариуцлагатай оролц л доо.

Г.Лувсан-Очир: Би өөрийнхөө цаг дээр өөрөө ярьчих уу, хэдүүлээ намайг ярьсны дараа наад юугаа үргэлжлүүлчих тэгэх үү?

Ц.Сандаг-Очир: Энэ 2 сайд юу гэх юм бэ?

Г.Лувсанжамц: Нэгэнт миний цаг яваад эхэлсэн учраас.../үг тасрав/

Ц.Сандаг-Очир: Яая гэсэн байр суурьтай байгаа юм бэ? Тэгээд сая санал хураалт явагдаад дүн гарчихлаа шүү дээ. Дэмжигдсэнгүй шүү дээ. Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл дарга минут.

О.Цогтгэрэл: Засгийн газрын 21-ээс 25 оны үндсэн чиглэл, 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр буюу мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэж байна. Үүнтэй холбоотой сая асуулт, хариултууд явж байна. Гишүүд тодруулж байна. Хариулж байгаа албан тушаалтнууд нь байхгүй, олон, олон ийм асуудлууд гарч байгаа. Хариулт хангалтгүй. Гишүүдэд материал үндсэндээ бараг нэг хоногийн зайтай аваад гишүүд танилцах олон асуудлууд, сая энэ гишүүдийн гарч байгаа хариулт дээр үнэхээр хангалтгүй хариултууд гараад байна л даа. Тэр үнэлгээний нэгдмэл байдал олон, олон талаасаа тэр түрүүчийн асуултууд. Ийм

учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн дүгнэлттэй холбоотой асуудлаар ажлын 3 хоногийн завсарлага авъя.

Ц.Сандаг-Очир: Гантөмөр сайд чинь ажлын 3 хоногт ирэх юм уу? Ажлын 3 хоногт чинь багтахгүй юм байна шүү дээ. Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл гишүүний гаргасан саналаар Байнгын хорооны хамтарсан хуралдаанаас завсарлага авлаа. Өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

16.16 цаг

Дараагийн хуралдаанд сайд нар өөрсдөө анхааралтай байх хуралдаа ирцгээ нэгд. 2-т холбогдох яамнуудын албан тушаалтнууд наад аудитын даргаасаа авхуулаад ирүүл. Хуульд албан тушаалаар нь танилцуулна гээд заачихсан байна. Гэтэл орлогчийг танилцуулна, аль нэг нь танилцуулна гэсэн үг, өгүүлбэр байхгүй байгаа шүү гэдгээс авхуулаад өнөөдрийн хуралдаанд 4, 5-хан сайд нар ирсэн байна. Тэгээд асуудлыг нь ярих болохоор төлөвлөгөө, төсвөө батлуулах болохоор гүйгээд байдаг. Гүйцэтгэл, тайлан ярих болохоор ирдэггүй. Тийм учраас өнөөдөр энэ гишүүд бухимдалтай байгаа нь өнөөдрийн хуралдаанаас завсарлага авах асуудлын үндсэн шалтгаан болж байна шүү дээ. Тийм учраас ЗГХЭГ, сайд нар энэ дараагийн хуралдаан дээр бүтэн бүрэлдэхүүнээрээ байж, гишүүдийн асуултад бүрэн дүүрэн мэдээлэл өгч, хариулт өгөх тал дээр онцгой анхаарал хандуулж ажиллахыг хүсье. Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА